

ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХҮРЭЭНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЙИЖ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖЛЫН
ТАЙЛАН

2015.07.01

Алтай хот

Тус хэлтсийн 2014 оны санхүүгийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд санхүү тайлангийн аудит хийгдлээ. Аудитын дүгнэлтээр өгсөн албан шаардлагын дагуу хийх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

1. Томилолтын хуудас, холбогдох анхан шатны баримтгүйгээр жолооч Ц.Өлзийбаатарт 5 хоногийн томилолт болох 60.0 мянган төгрөгийг илүү олгосон.
 - Жолооч Ц.Өлзийбаатарын цалингаас 60.000 төгрөгийг суутган авч 05000982 тоот дансанд төвлөрүүлээ.
2. Малчин өрхийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан малчдын мал маллагааны технологийн болон аж ахуй эрхлэлтийн сургалт, бизнес инкубацийн өрхийн зардлыг өрх тус бүрээр тооцож үзэхэд нийт 1402.9 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан.
 - Аудитын актын талаар сумдын төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүдийн сургалт, хөтөлбөрт хамрагдсан малчидтай төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нар утсаар холбогдож танилцуулан ажиллалаа. Одоогийн байдлаар 436700 төгрөгийг төрийн сангийн татварын бус орлогын дансанд төвлөрүүлээд байна.
3. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малчин өрхийг дэмжих арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангаагүй 6 өрхийг 30000.0 мянган төгрөгөөр малжуулсан зөрчил илэрлээ. Эдгээр өрхийн малыг буцаан авч шаардлага хангахуйц өрхтэй гэрээ хийн, шилжүүлэн өгөх ажлыг зохион байгуулах.
 - 2014 онд МХЭД хөтөлбөрт хамрагдаж хөтөлбөрийн шаардлага хангаагүй 6 өрхөөс Цээл сумын Бүрэнжаргалан багийн малчин А.Гантулгаас тус багийн малчин Б.Баярсайханд, Тонхил сумын Алтансоёмбо багийн малчин С.Цэрэнпилээс тус багийн малчин Р.Амарсанаад, Содномдаржаагаас тус багийн малчин С.Эрхэмбаяр, Төгрөг сумын 5-р багийн малчин Х.Нанжидаас 2-р багийн малчин Д.Гантөмөрт, 2-р багийн малчин Б.Нямдариас 2-р багийн малчин Ү.Амгаланбаатар нарт холбогдох хууль журмын дагуу бичиг баримтыг нь үндэслэн малжуулах арга хэмжээг 2015 оны 04 дүгээр сарын 23-27-ны хооронд зохион байгууллаа. Жаргалан сумын Завхан гол багийн малчин Д.Билэгбатыг малжуулах арга хэмжээнд бичиг баримтын зөрчил гарсаныг сумын Засаг даргын Тодорхойлолт, 2013 оны мал тооллогын А данс зэргээр залруулсан болно.

4. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг дахин давтан гаргасан, өөрийн хариуцсан ажилдаа хариуцлагагүй хандсан дотоод хяналтын мэргэжилтэн Б.Баярмаа, ахлах мэргэжилтэн Н.Баярсайхан нарт хуулийн дагуу хариуцлага тооц.
- Өмнөх оны зөрчил дутагдал болон тухайн онд хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн талаар дотоод хяналтын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН :

МЭРГЭЖИЛТЭН



Б.БАЯРМАА